



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 2 сарын 19 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Урьчилан сэргийлэх талаар хэрэгжүүлэх
арга хэмжээний тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дүгээр заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2 дугаар заалт, Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 62 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн зөвлөмж, тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Томуу,томуу төст өвчний өвчлөл,тархалт болон Шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 00 цаг хүртэл тус газарт нийтийг хамарсан хурал цуглаан, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосугай.

2.Улсын Онцгой Комисс болон Эрүүл мэндийн яамнаас гарсан шийдвэр, зөвлөмжүүдийг дагаж биелүүлэх ,ажлын байр болон иргэдэд үйлчилдэг танхимд ариутгал халдваргүйжилтийг тогтмол хийх, амны хаалт хэрэглэх,орох, гарах хөдөлгөөний хаах шийдвэр гарсан аймгуудад зорчихгүй байхыг нийт албан хаагчид үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга / С.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА Ц.АЗБАЯР